**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН**
**/2022.01.17 - 2022.01.21/**

2022.01.21 Дархан-Уул аймаг

| № | Ажлын чиглэл | Үйл ажиллагааны гүйцэтгэл |
|---|---|---|
| | | **Барилга хот байгуулалтын хэлтэс** |
| 1 | Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэл | ✓ Дархан-Уул аймагт Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа 29 ААНБ-уудаас Барилга, Хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019,12,18-ны өдрийн 206, А/184 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2021 оны мэдээг хүлээн авсан. 2022 оны 1 сарын 20-ны байдлаар 20 мэдээ ирсэн байна. Хугацаа болоогүй шалтгаанаар бусад ААНБ үйлдвэрлэлийн мэдээ ирүүлээгүй байна.<br>✓ УГСАРМАЛ ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ АУДИТ хийх цахим сургалтанд хамрагдав. |
| | | **Газрын удирдлагын хэлтэс** |
| 1 | Дархан сумын газрын даамал | ✓ Дархан суманд гэр бүлийн хэрэгцээний зориулалттай өмчилсөн газраа бусдад шилжүүлсэн худалдсан 8 бэлэглэсэн 2 иргэний кадастрын мэдээллийн сангийн өөрчлөлтийг хийж цахим системд бүртгэсэн. Мөн дархан суманд газар эзэмшиж, ашиглаж байгаа 7 иргэн, хуулийн этгээдийн кадастрын зургийг тус тус гаргаж өгсөн.<br>✓ Мэдээллийн санд бүртгэгдээгүй газар өмчилсөн 3 иргэний нөхөн бүрдүүлж цахимжуулсан.<br>✓ Шинээр газар өмчилсөн 8 иргэний өмчлөлийн захирамж, кадастрын зураг, хянан баталгааны дүгнэлтийн хуудасыг хэвлэн нэгж талбарын хувийн хэрэг үүсгэн баталгаажуулалтыг хийлээ.<br>✓ Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хуралд танилцуулах 21 иргэний өргөдөл хүсэлттэй танилцан суурин судалгааг хийж хуралд танилцуулах танилцуулга бэлтгэж байна.<br>✓ Өмнөх хурлаар орж өмнө газар өмчилсөн 5 иргэнд хариу мэдэгдэх худасаар хариуг хүргүүллээ. |
| 2 | Кадаст, геодези, зураг зүйн чиглэл | Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, “Ёлт сүрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн доорхи ажлыг шалгаж хүлээн авсан. Үүнд:<br>✓ Дархан сум. 11-р баг. 13-р хороолол. Үндэсний эрх чөлөө 3-315 Б блок улаан шугам<br>✓ Хаягийн зургийн дагуу 11 иргэн, 11 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.<br>✓ Шинэчлэн бүртгэлд хамрагдаагүй 2 иргэн 0 аж ахуй нэгж, газраа хуваaж бусдад шилжүүлсэн 4 иргэний эзэмшил, өмчлөлийг газрыг ажлын нэгж талбарт шилжүүлсэн.<br>✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн 8 иргэн, 1 аж ахйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. |
| 3 | Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн чиглэл | ✓ Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуутгээдийн нийт 5 албан бичгийн лавлагааг мэдээллийн сан болон газар өмчлөх захирамжаас шүүж хариуг хүргүүлсэн.<br>✓ Иргэн С.Эрдэнэбат нь эзэмшил газраа цуцлуулах хүсэлт өгсөн. Хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулсан.<br>✓ Цахим танхимд хуваарийн дагуу 2022-01-19 өдөр ажилласан. Нийт 12 өргөдөл илгээсэн |
| | | **Захиргаа аж ахуйн чиглэл** |
| 1 | Хүний нөөц, дотоод асуудал | Хүний нөөц:<br>✓ Хүний нөөцийн цахим системд албан хаагчдын бүртгэлийг шинэчлэн оруулсан.<br>✓ Аймгийн Засаг дарга, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, ГХБХБГ-ын Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулхаар ГЗБГЗЗГ-ын ахлах мэргэжилтэн Г.Мөнхцэцэгт munkhtsetseg.ga@gazar.gov.mn хаягт хүргүүлсэн.<br>✓ Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн 71,73 дугаар тогтоолын дагуу тусгай шалгалтаар хамгийн |

| | | |
|---|---|---|
| | | өндөр оноо авсан Ч.Үүрийнтуяаг Орхон сумын газрын даамлаар, Хот байгуулалтын кадастр, зураг төсөл хариуцсан мэргэжилтнээр М.Дарьсүрэнг нарийг газрын даргын тушаалаар томилж ажлыг хүлээлцсэн. 72 дугаар тогтоолоор Суурь судалгаа, газрын мониторингын асуудал хариуцсан мэргэжилтнээр Ү.Оюундарийн нэр ирсэн боловч өөрөө ажилд орох эсэхээ бүрэн шийдээгүй тул хойшлуулсан.<br>✓ Нийт албан хаагчдаа ковидын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагч бүрийг 50 ширхэг маскаар хангасан.<br>Сургалт, зөвлөгөөн:<br>✓ ТАУИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулах харилцааны талаар УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулсан 7 хоног бүрийн Пүрэв гаригийн сургалтад цахимаар хамрагдсан.<br>✓ ГЗБГЗЗГ-аас удирдах ажилтны зөвлөгөөнөөр шилдэг байгууллага, дарга, нэгжийн дарга, даамал, мэргэжилтэн гэх мэт шалгуураар байр эзлүүлж, 2021 оны тайлан, 2022 оны төлөвлөгөөг батлуулж 21 аймгийн хэмжээнд удирдлагууд оролцсон. |

Тайлан боловсруулсан:

Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Золбаясах

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга Г.Нямдорж